

# One Nation Built on the Strength of Immigrants

One Nation Commission Report



# Баримт сэлт, гүйцэтгэлийн тайлан

1. Олон талын судалгаа, цагаач иргэдийн хүч чадалд тулгуурласан нэг үндэстэн бий болгох гэсэн Америкийн Нэгдсэн Улсын баримт нотолгоот, ёс зүйн хэлэлцүүлэг нь цагаач иргэдэд тавьсан хатуу ширүүн хязгаарлалт буюу Олон нийтэд хандсан хориг арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал, санаачилгын дагуу Холбооны бүртгэлийн газарт хаягласан 250,000 гаруй санал асуулга, тайлан мэдээ хүлээн аваад байна.

2. Цагаач иргэд нь ажиллах хүчийг сайжруулах, эдийн засгийн хөгжүүлэх, татварын нэмэх, шинэ хөгжингүй нийгмийг бүтээх, баялаг соёлыг бий болгох, санал санаачилга, шинэлэг санал, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн дэмжих, эрүүл аюулгүй гэр бүл, халамжийн тогтолцоог бэхжүүлэх илүү хүчирхэг Америкийг бий болгож байдаг.

3. Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийн нөлөөлөл дуу хоолойны тал дээр хийсэн холбогдох баримт сэлт, судалгаа нь үндсэндээ Америк-бус гэдгийг илт мэдэг баримтжуулан, 2019 онд гаргасан шинэ халамжийн хуулийн дагуу цагаач иргэдийг илт гадуурхаж буй харгис хориг арга хэмжээ болохыг харуулж байна.

4. Олон төрлийн баримт сэлт, хүн төрөлхтний түүхийн дагуу Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийн талаарх буруу ташаа ойлголтыг арилгахад чиглэгдэж байна. Цагаач иргэд дээр тавигдах ерөнхий ойлголт, дүрс зургаас сөргөөр, тэдгээр цагаач иргэд Америк иргэдэд заналхийлэл болж, Америкийн ажиллах хүчийг цагаач иргэд бүрдүүлж иргэдийг орж буй хэмээгээд энэ нь эдийн засагт эзлэх цагаач иргэдийн байр суурины нөлөө их байгааг харуулж байна гэжээ.

5. Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийн нийгэмлэг нь бусад төрлийн арьс, нийгмийн анги бүлэг, угсаатан зүйн бүлгээс илүү харьцангуй олон цагаач иргэдтэй бөгөөд энэхүү Нэг үндэстний комиссын тайланг өргөнөөр олон нийтэд тарааж, Азийн есөн хэл рүү орчуулж, кино болгон олонд түгээж байна.

6. Санал өгөгчдийн судалгаагаар, Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийг багтаасан цагаач иргэд нь сонгуулийн саналыг өөрчлөхөд чухал хүчин чадалтай, олон нийтийн саналыг өөрчлөхүйц, шийдвэрийн үр дүнд нөлөөлж чадахуйц, цагаач иргэдийн судалгааны тоймд дурдагдсан.

7. Эрүүл мэндийн нийгмийн халамж дээр хийгдсэн судалгаа нь эрүүл мэндийн нөхөн олговор, даатгалын санаг цагаач иргэд бүрдүүлдэг болохыг тун дэлгэрэнгүй харуулсан болно. Цагаач иргэд нь АНУ-д мэндэлсэн иргэдээс илүү бага олон нийтийн тэтгэмж улсын халамжийн мөн авдаг бөгөөд, энэ нь татварын тогтолцоо, бусад олон нийтийн дэд бүтэцтэй шууд холбоотой, мөн манай үндэстний олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн сайн сайхны тусад чухалд тооцогддог байна.

8. Зоригт сонгогдсон албан тушаалтан, ашгийн бус гүйцэтгэх хүчин, хүмүүнлэгийн ажилтнууд хөдөлгөөн зохион байгуулж энэ нь улам бүр газар авч байгаа нь шүүх, Конгрессын танхимууд хуулийн байгууллагатай дайн зарлаж, түүндээ бэлтгэх ба улс орны хүчирхэгжүүлдэг цагаач иргэдэд итгэл найдвар, хүсэл тэмүүлэл өгч, Америкийг хүчирхэгжүүлэгч жинхэнэ бодит түүхийг батлан харуулах юм.

9. Нэг үндэстэн комиссын дагуу цагаач иргэдийн судалгааг бодитоор явуулж, өөрсдийн дэмжигч, комисс, зөвлөхөд мэдэгдэнэ. Энэхүү гарын авлага нь шийдвэр гаргагч, сэтгүүлчид, нэр дэвшигч нарт гарын албан байдлаар бэлтгэхээр оролцлоо. Сонгогчдын үзэж судалснаар сая цагаач иргэд нь америкийг илүү хүчирхэг нийгэмтэй болоход хүчин чармайлт гаргаж ажилласаар байх болно.

# Зөвлөмжүүд

## Нэн даруй

»»» Олон жилийн түүхтэй, 150 жилийн настай стандартыг 1999 онд тодотгож, Конгрессоос гаргасан бөгөөд үүнийг Medicaid Нийгмийн халамжийн дүрэм, хүнсний купон, орон сууцны дэмжлэгт оруулахаас татгалзсан юм. Нэг Үндэстэн Хороо нь мөнгөн тэтгэмж, урт хугацааны халамжаас бусад тохиолдолд Нийгмийн халамж нь нийтийн тэтгэмжид хамаарахгүй болохыг зөвлөмж байна.

## Ойрын хугацаанд

»»» Нийгмийн халамжийн хэрэгжүүлэлтийг хориглох зорилгоор холбооны, мужийн, тойргийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, шийдвэрийг дэмжинэ.

»»» Нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэхэд зориулан холбооны санхүүжилт гаргахаас урьдчилан сэргийлж Конгрессын болон Сенатын хууль тогтоомжийг дэмжинэ.

»»» Шинэчлэн найруулсан Нийгмийн халамжийн дүрмийн хэрэгжилтийг хориглохыг уриалсан төрийн тогтоолуудыг дэмжинэ.

»»» Шинэчлэн найруулсан Нийгмийн халамжийн дүрмийг буруушааж буй тойргийн болон бусад орон нутгийн тогтоол, хэлийг дэмжинэ.

**Урт хугацаанд** >>> Цагаачид эдгээр эрэгт цөөн эх үүсвэрээр ирж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч цаг хугацаа өнгөрөхөд тэд улс орны эдийн засаг, сайн сайхан, нийгэмд хувь нэмэр оруулж, ашиг тусаа өгдөг болохыг харуулсан АНУ-д цагаачлалын баримт, түүх, хүн төрөлхтний талаарх ойлголтыг сурталчилна. Нэг Үндэстэн Хорооноос манай үндэсний, муж, орон нутгийн бодлого, хуулиуд цагаачдыг хүлээн авч, угтаж, хамгаалахыг зөвлөж байна.


>>> Цагаачдад англи хэлийг эзэмшиж, тэдний шашин шүтлэг, соёлын эрхийг баталгаажуулж эх хэлийг нь дэмжих замаар АНУ-д амжилттай шилжихийг дэмжинэ.

>>> Бүх гишүүд суурь үйлчилгээ, боломжийн аюулгүй байдлын сүлжээнд хамрагдаж чадах үед эдийн засаг, нийгэм хөгжиж байдгийг нотолсон баримт, мэдээллийг өгснөөр бүх оршин суугчдад зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжинэ.

>>> Тархины хөгжил, эрдэм шинжилгээний ажил, амжилтанд хүрэхэд хангалттай хоол тэжээл байгаа үед хүмүүс цэцэглэн хөгжиж, сурч, амжилтанд хүрдэг болхоор гэр бүл, хүүхдүүдийг хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлээр хангана.

>>> Аюулгүй, тохь тухтай байраар хангагдсан гэр бүл, үр хүүхдүүд амжилтанд хүрэх боломжтой бол байр, байраар хангах эрх, тусламж үзүүлэхийг дэмжинэ.

>>> Америкийн ирээдүйн ажиллах хүчний хэрэгцээг хангах, улс орныхоо эрүүл мэндийг хангахын тулд цагаачдын ач холбогдлыг тусгасан цагаачлалын хууль тогтоомж, бодлого боловсруулна.



# **ААPI Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд тоон зөрөө Америкийн хүн ам хамгийн хурдан өсөлттэй байгаа нь цагаачдын тоо нэмэгдэж байгаад юм.**

Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд (AAPIs) нь Америкийн хамгийн хурдан өсөж буй өнгөт арьс иргэдийг хэлэх бөгөөд тэд бусад бүлгүүдтэй харьцуулахад анхдагч цагаач иргэд гэгддэг билээ. Төөрөгдөлтэй, буруу ташаа мэдээ, таамаглал, үл тоомсорлолт нь олон нийтийн төдийгүй, шийдвэр гаргагчид, удирдагчдын бодлыг төөрөгдүүлж байна. Тэд анх Америк улсад ирэхдээ цагаач иргэд, зөвхөн өөрсдийн ашиг тусын тулд Ази гаралтай бүх Америкчуудыг төлөөлөх "цөөнх" аль эсхүл "сэжиг бүхий түрэмгийлэгч" хэмээн буруу ташаа ойлгогдож, энэ мэт түгээмэл хэвшмэл ойлголттой байлаа.

Харин эсрэгээрээ, эрт үеийн Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд нь Америкийг тив дамнасан хурдын замтай болгож, Хавайн өргөн удам газарт тариалан эрхлэн ажиллаж, түүнчлэн АНУ-ын Баруун эргийн хөдөө аж ахуй, фирмийн үйлдвэрлэл, загас анх агнуурын лаазалсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг явуулсан гэдэг. Гэхдээ, эдгээр тэдний эрт үед оруулсан хувьд нэмэр түүхээс арчигдаж, үндсэндээ хуулиар шахагдаж байгаа бөгөөд манай үндэсний нэгдмэл түүхэнд балархай хуудас үлдээж байна. Гэтэл өнөөдөр Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн тэдгээр иргэдийн хийсэн бүхэн зүгээр л зүй ёсны зүйл байсан гэгдэж байна.

Сүүлийн үед, Америкийн дээд албан тушаалтнуудын заримын үзэж буйгаар, цагаач иргэд, тэр дундаа Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн тэдгээр иргэд улс үндэсний нөөцийг нэмэгдүүлэхэд ачааллын урсгал бий болгож, тэр дундаа Европын бус цагаач иргэд улсаас хараат байж, улсын халамжаар амьдарч байна хэмээн буруушааж, энэ мэт сэтгэгдлийг улам бүр нэмэгдүүлээд байна. Гэхдээ Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийн бодит тоо баримт нь таамаглал төдий, нарийн бодиттой бус, харин ч Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд энэ улсад оруулсан ашиг тус, улсын ажиллах хүчний нөөцийг нэмэгдүүлж байгааг нотолж байна.

**Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд нь АНУ-ын хүн амын томоохон хувийг эзлэх, хурдацтай өсөн нэмэгдэж буй бүлэг юм.**

• Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн олон үндэстэн холилдсон, өнгөт арьс энэ бүлэг нь өдгөө АНУ-ын хүн амын 7 хүртэл хувийг эзлэх бөгөөд 2065 онд энэ тоо 3 дахин нэмэгдэнэ гэж үзэж байгаа нь 24 гаруй орны 50 гаруй үндэс ястнаас бүлдсэн 100+ хэл соёл бүхий 12 төрлийн шашин шүтлэгтэй 24 сая хол давсан иргэдийг бий болгоно хэмээн харж байна.

Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийн талаас илүү хувь нь өөр оронд төрсөн [1], 1965 оноос хойш АНУ-п ирсэн бүх цагаачдын 4/1 нь Ази гаралтай цагаач иргэд гэсэн тоо баримт бий.[2]

**Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд нь АНУ-ын эдийн засаг, нийгэмд үйлчлүүлэгч, хэрэглэгч, ажилчин анги, бизнес эрхлэгч, оюун өмч эзэмшигч, иргэдийн амьдралд оролцогч бүхий зайлшгүй оршин байх бүлэг гэж хэлж болно.**

• Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд нь бусад хүн амзүйн бүлгүүдтэй адил өөр өөр гарал үүсэл, өрхийн орлого, боловсролын байдал, янз бүрийн ажил мэргэжил бүхий төрөл бүрийн иргэдээс хамаарах хэдий ч 2015 оны байдлаар худалдан авалтын чадвараараа нийтдээ \$455.6 тэрбумд хүрсэн хөрөнгө оруулалт хийсэн тооцоолол бий. [3]

• Цагаач иргэдийн нийт өрхийн орлогын хамгийн өндөр нь худалдан авалтын чадвараараа бусад олон өрхийн гишүүдээс дундаж байдлаар авч үзвэл 2015 онд \$75,000 байсан нь АНУ-ын ерөнхий өрхийн дундаж орлогоос (\$55,300)-с өндөр юм. [4]



- Түүнчлэн Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн эзэмшиж буй 555,262 тооны бизнес аж ахуй нэгжийн орлого 2016 оны байдлаар нийтдээ \$691 тэрбум байгаа нь бусад жижиг бүлгүүдээс өндөр, түүнчлэн бусад жижиг бүлгүүдээс илүү өндөр буй АНУ-д 4,4 сая гаруй ажиллагсадтай байна. [5]

- Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн өрх гэр бүлүүд нь олон нийтийн хөрөнгө өмчлөлийн нэгэн чухал нөөц бөгөөд засгийн газарт дангаар татвар төлсөн байдал нь 2012 онд \$184 тэрбум байжээ. [6]

### **Өнөөдрийн Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд нь харьцангуй өндөр боловсрол эзэмшдэг төдийгүй Америкийн ажиллах хүчийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй.**

- 2015 онд, дангаар Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн 60 гаруй хувь нь 25 буюу түүнээс дээш насны байсан бөгөөд багадаа бакалавр зэрэгтэй, нийт Америкт төрсөн иргэдтэй харьцуулахад 2 дахин өндөр боловсролтой байв. [7] Нэг ижил насны Азиуд нь үүнтэй харьцуулахад 2017 онд бүрэн дунд буюу түүнтэй тэнцэх боловсролтой байв. [8]

- Ажиллаж буй Ази эмэгтэйчүүд нь бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад удирдах албан тушаал, мэргэжлийн болон бусад албан тушаал дээр илүүтэй ажиллаж байгаа нь: Ази эмэгтэйчүүдийн 50 хувь нь бусад цагаан арьст эмэгтэйчүүдийн 45 хувьтай тэнцэж байв. Ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийн 20 хувь нь мэргэжлийн болон бизнес үйлчилгээний байгууллагад ажиллаж байгаа нь бусад цагаан арьстнуудтай/13 хувь нь/ харьцуулахад харьцангуй өндөр тоо юм. [9]



**Ази-Америкийн санал асуулга нь ялалтыг ахиулахад хангалтай хэмээн, Нью Йоркоос нэр дэвшигч DNC/Ардчиллын үндэсний хороо/-ны дэд дарга, АНУ-ын төлөөлөгч Grace Meng мэдэгдсэн гэж, NBC телевиз-д 2019 оны 03-р сарын 26-д мэдэгдлээ. Тэрээр Висконсин, Миннесота, Техас, Калифорния, Невада мужийн ААPI/ Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд/ ирэх жилийн ерөнхийлөгчийн сонгуульд шийдвэрлэх нөлөө үзүүлнэ гэж итгэлтэй байгаагаа дурдлаа. [26]**

**Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд нь дэлхийн эдийн засагт өрсөлдөхүйц үндэсний шинжлэх ухааны болоод техникийн өрсөлдөгч болоход түлхэц үзүүлж байна.**

- Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд нь шинжлэх ухаан, технологи, инженерийн, математикийн салбарт ажиллаж байгаа нь ерөнхий Америк ажилтан ангитай харьцуулахад хоёр дахин илүүтэй тооны хүн ам ажиллаж байна.
- 2003-2012 оны хооронд шинээр 680,000 гаруй Ази гаралтай мэргэжилтнүүд шинжлэх ухаан, технологи, инженерийн, математикийн болон бусад салбарт мэргэжилд дээшлүүлж, 2011 онд дангаар Энэтхэг, Хятад улсаас ирсэн H-1B визтэй анхдагч иргэдийн 62 хувь буюу (66,137) тооны хүмүүс техникийн салбарт ажиллаж байв. [10]

**Америкийн хүн амын насжилтын үзүүлэлтээс улбаалан 2018 оны эрүүл мэндийн халамж үйлчилгээ нь АНУ-д хамгийн томд тооцогдох ажиллах хүчний салбар болох үйлдвэрлэл, жижиглэн худалдааны салбарыг даван гарч хамгийн том ажил эрхлэлтийн салбар болжээ. Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд архаг хэлбэрийн, хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд томоохон байр суурь эзэлдэг. [11]**

• Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд нь эрүүл мэндийн мэргэжилтнээр ажиллаж буй тоо нь бусад коллеж төгссөн Америкчуудтай харьцуулахад ажил эрхлэлтээрээ хоёр дахин байна. [12]

• АНУ-ын Хүн Амын сангийн тооллогоор 2016 оны байдлаар 164,000 эрүүл мэндийн халамж үйлчилгээний мэргэжилтнүүд байгаагийн бараг 17 хувь нь гадаадад төрсөн иргэд буй Азиас хамгийн их эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг эрүүлдэг буюу нийт ажиллах хүчний 6 орчим хувийг эзэлдэг байна. [13]

• 1980-иад оны дунд үеийг хүртэл АНУ дахь нийт гадаад сувилагчдын 75 хувийг Филиппиний сувилагчид эзэлж байсан бол Филиппин улсаас ирсэн сувилагч цагаагч иргэд өнөөг хүртэл гадаад сувилагч цагаагч иргэдийн ихэнх хувийг эзэлсээр байна. [14]

**Халамжийн үйлчилгээ үзүүлдэг салбар нь энэ салбарт Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн эзлэх хувь өндөр АНУ-ын өндөр насжилт бүхий хүн амаас үүдэн хамгийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээт салбарын нэгт тооцогдох болжээ.**

• Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн хувь хүний нийгмийн халамж үйлчилгээ, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сувилагчийн туслагч асрах үйлчилгээ, өндөр настнуудад туслах, гэрт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах зэрэг ажил эрхлэх байдлаараа 2016 онд нийт гэрийн асаргаа, халамж үйлчилгээний ажиллагсдаас 2 сая гаруй хувь буй хүн амын найман хувь болох (160,000) америк иргэдийг асарч байв. [15]

**Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд нь АНУ-ын сонгуульд үнэлэхүйц өндөр хүчин нөлөөтэй болж буй бөгөөд иргэний оролцоо өндөр түвшинд байдаг.**

• Хэдийгээр үндэсний үзүүлэлт яс үндэс, гарал угсаа ялгаатай байдаг ч Ази цагаагч иргэдийн 58 хувь нь Америкийн Нэгдсэн улсын иргэншилтэй юм. [16]

• 2000-2008 оны хооронд Ази гаралтай Америк иргэд, сонгогчдын тоо ойролцоогоор 50 хувиар өсөж [17] мөн энэ тоо 2020 гэхэд 13,7 саяд хүрнэ гэж тооцоолж байна., [18]

• 2016 оны байдлаар Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн бүртгэлтэй сонгогчдын тоо өсөж 2000 оны байдлаар 2,4 сая орчимд байсан тоо 5,8 саяд хүрчээ. 38 хувь нь аль нэг намын харьяалалгүй байсан байна. [19]

- Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд улам бүр конгресс-д ажиллах болж: 2008 онд 8 хүн; 2010 онд 10 хүн; 2012 онд гуч байсан бол энэ тоо 2014 онд 39 хүрч, 2016 онд 40, 2018 оны байдлаар 80 хол гарсан байна. [20]

- Одоогоор Ази, Номхон далайн орнуудын цагаагч 600 гаруй иргэд засгийн газарт төрөл бүрийн албан тушаалд ажиллаж байна. [21]

## **Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд сонгогчид олон сонгуулийн тойргууд, хоёр намт мужуудад шийдвэрлэхүйц нөлөө үзүүлэх нь улам бүр нэмэгдэж байна.**


- Ойролцоогоор Конгрессын дөрвөн дүүрэгт нэгт нь багадаа Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд орчин суугчдын 5-с илүү хувь, нийт хүн амын 5-аас илүү хувийг Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд эзэлдэг 600 орчим хот, захиргаа бий. [22]

- Эрх бүхий Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэд сонгогчид 7 мужийн сонгуулийн тойргийн 5 хувиас дээш хүн амыг бүрдүүлдэг: Үүнд Хавай, Калифорниа, Невада, Вашингтон, Нью Жерсье, Нью Йорк, Аласка багтана. [23] Невада, Аризона, Хойд Каролина –гурван мужуудад нь Ази, Номхон далайн орнуудын цагаагч иргэдийн тоо улам бүр нэмэгдэж буй “хоёр намын засаглалт мужууд” юм. [24]

- 2018 оны дунд үед, Ази гаралтай Америкчууд, Номхон далайн орны цагаагч иргэд нь 11 мужид 27 конгрессын дүүргүүдэд нөлөөлөх үүрэг гүйцэтгэсэн. [25]

**Судалгааг боловсруулж сийрүүлсэн Рене Кириа-Круз нь хэвлэлийн тоймч, АНУ-ын Inquirer.net. веб санал асуулга хариуцсан дарга болно.**

###



# ЦАГААЧ ИРГЭД АМЕРИК ОРНЫГ УЛАМ БҮР ХҮЧИРХЭГЖҮҮЛДЭГ

Америкийн үнэ цэнэ гэдэг ойлголт нь үндсэндээ Эрх чөлөөний хөшөөн дээр сийлсэн байдагчлан нэг зуунаас ч илүү хугацааг үдээд буй цагаач иргэдэд холбооны бодлогоор бага орлого, хууль ёсны цагаачдад засгийн газрын ивээл дор эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хоол хүнс, орон сууцаар хангагдах боломж л олгосон түүхэн цаг хугацааг хөндөж байна.

Өмнөх ерөнхийлөгчид цагаач иргэдийг энэрэлдээ багтааж, тэдний энэ улсад оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлсэн: Тухайлбал (Жон Фицджеральд Кеннеди энэ улс үндэстэн цагаач иргэдээс гаралтай хэмээн бичжээ, Роналд Рейган нь Америкчууд бусад улс орон бүрээс, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн иргэдээр хүчирхэгжиж байна гэж дурдаж байв, харин Жорж Уокер Буш “шударга гэр бүл” хуулийн заалтын 1990 оны цагаачлалын тухай хуульд оруулж баталснаар, Жорж Уокер Буш болон Барак Обама нар бичиг баримтгүй цагаач иргэдэд иргэншил олгох замыг бий болгосон түүхтэй.

Шинэ улсад нүүн шилжин суурших нь хэцүү бөгөөд шинээр нүүж ирсэн хүмүүст Америкт байр сууриа олоход тусламж маш их хэрэгтэй байдаг. Цагаачдад ихэвчлэн түр зуурын орлого багатай ажил олдох ба ажилчдын нийгмийн хангамж муу эсвэл байхгүй байх нь элбэг байдаг.

Холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал батлагдвал ирээдүйд хэзээ нэгэн өдөр эрүүл мэнд, хоол хүнс, орон байрны хөнгөлөлт эдлэн энэ улсад өөрийн хувь нэмрээ оруулж буй цагаач иргэдийг холбооны засгийн газрын тэтгэмжийг ашиглахыг хориглож энэ улсад нэвтрэх эрхийг хааж буй хэрэг юм. Энэ ч утгаараа Англи хэлний мэдлэг дутмаг, боловсролоор тааруу, бага орлоготой, хөгшин, залуу, хүүхэд төрүүлэх насны цагаач иргэд АНУ-д нэвтрэх, ногоон карт авахад улам бүр л бэрх болох болно. Энэ нь "улсын тэтгэмж" олгох явдлыг болиулж, урт хугацааны бодлого, энэ үндэсний журамт ёс, урт хугацааны бодлого, зарчимд шууд заналхийлж буй хэрэг юм.

Хэдийгээр сөрөг, буруу ташаа хандлага байвч, олон тооны судалгаа, баримт сэлтээс үзэхэд цагаач иргэд энэ улс, үндэстэн нийгэмд оруулсан ашиг тус их бөгөөд Америк орныг улам бүр хүчирхэгжүүлж буй гэдгийг баталсаар байна.

## **Цагаач иргэдэд түшиглэсэн Америкийн Эрүүл мэндийн салбар**

Америкийн Нэгдсэн улсын дөрвөн эмч тутмын нэгээс илүү нь өөр оронд төрсөн байхаас гадна өөр нэгэн шинж судалгаагаар маш олон тооны сувилагч, шүдний эмч, эм зүйч, гэрийн эрүүл мэндийн асрагчид цагаач иргэд байгаа баримт бий. [27]

- Эмч нарын 29 хувь орчин нь өөр улсад төрсөн бараг 7 хувь орчин Америк улсын иргэн биш болох нь судалгаагаар нотлогджээ.
- Шүдний эмч нарын барагцаагаар 24 хувь нь АНУ-ын цагаач иргэд бөгөөд дөрвөн хувь нь тус улсын иргэн биш байдаг байна.
- Эм зүйч нарын тухайд, 20 хувь нь өөр аль нэг оронд төрсөн, тэдгээрээс бараг дөрвөн хувь нь Америкийн иргэн биш болно.
- Гэрийн асаргааны эрүүл, сэтгэцийн болон сувилагчийн туслах зэрэг үйлчилгээний ажлыг 23 хувиас илүү Америк уугуул биш хүмүүс, тэдгээрээс бараг 9 хувь нь иргэншилгүй байдаг байна.

### **Цагаач иргэд Нийгмийн халамж авахаар АНУ-д ирдэггүй**

- Улсын нийгмийн халамж нь АНУ-аас бичиг баримтгүй иргэдэд нийгмийн халамж олгодоггүй тул иргэд цагаачлах шалтгаан нь халамжийн мөн биш бөгөөд цагаач иргэд тус улсад ирснээс хойш 5 жилийн хугацаанд голлох холбооны халамж, үйлчилгээний хөтөлбөрт одоогийн хуулиар орох боломжгүй юм. [28]



АНУ-д байгаа цагаач иргэд АНУ-д төрсөн иргэдээс бага улсын тэтгэмжийг мөнгө авдаг. [29]

- Калифорни хотод гэхэд холбооны тэтгэмжтэй харьцуулахад нийгмийн халамжид илүү мужийн хангалт хүртээмж элбэг бөгөөд Калифорнийн Эрүүл мэндийн Ярилцлагын судалгаагаар улсын нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдсаны хамгийн ихэнх хувийн АНУ-д төрсөн иргэд эзэлж байгаа судалгаа байна: Эрүүл мэндийн тэтгэмжийн 70 хувь, хоол хүнсний картын 72 хувь, хүүхдүүдтэй гэр бүлийн 76 хувь, нийгмийн халамжаар амьдрагсдын 68 хувь нь тус тус Америкт төрсөн иргэд байна.

Цагаач иргэд эрүүл мэндийн салбарт хийгддэгээсээ илүү их санхүүгийн хөрөнгө оруулалтыг тус улсад хийдэг. [30]

- Холбооны бодлогын дагуу АНУ-д ирсэн хязгаарлагдмал тооны цагаач иргэд нь тоо хэмжээний хувьд “эрс буурч” магадгүй юм. Цагаач иргэд нь хувийн даатгалын эрсдэлд орох эрсдэлтэй. Энэ нь цагаач иргэд даатгалд хамрагдах боломж муу, эрсдэлтэй байдаг улмаас эрүүл мэндийн хувьд эрсдэл хүлээдэг.
- Цагаач иргэдийн ойролцоогоор 13 хувь нь хувиасаа нийгмийн даатгал төлөгч иргэд боловч түүний ердөө 9 хувь нь буцаан олгогдож зарцуулагддаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл дунджаар, эрүүл мэндийн зардалд төлж буйгаасаа илүү ихийг тэд улсад төлдөг.
- Жилийн эрүүл мэндийн даатгалаас \$1,123 нь эрүүл мэндийн халамжийн зардалд цагаач иргэдэд олгогддог байхад харин энэ нь Америкт төрсөн иргэний хувьд ноогдох дүнгээс 163 доллар дутуу юм.

Хувийн болон улсын даатгалын нөөцөөс тогтоож буй Нэг хүнд ногдох зардал нь цагаач иргэдэд харьцангуй бага байдаг. [31]

- Эрүүл мэндийн халамжийн зардал нь цагаач иргэдийн хувьд Америкт төрсөн хүмүүстэй харьцуулахад  $0,5-2/3$  нь зарцуулагддаг.
- Нийт АНУ-ын хүн амын 12 хувь орчин нь цагаач иргэд бөгөөд байх бөгөөд тэд улсынхэмжээнд харьцуулахад нийт эрүүл мэндийн зардлын ердөө 8,6 хувийг л эзэлдэг.
- Мөн цагаач иргэд нь өөрсдийн эрүүл мэндэд зарцуулж буйгаас хавьгүй илүү хөрөг оруулалт улсад оруулж ингэснээр Эрүүл мэндийн үйлчилгээний санг бүрдүүлэгч голлох хөрөнгө оруулагч гэж үздэг. [30]

Цагаач иргэд нь улсын хэмжээнд дутмаг байгаа ажлын байр буюу АНУ-ын эрүүл мэндийн салбарт асар их хэрэгцээтэй. [32]

- 2017 онд нийт эрүүл мэндийн ажиллагсдын 18 хувь нь цагаач иргэд, нийт урт хугацааны халамжийн ажиллагсдын 23 хувь нь гадна иргэд байв.
- Цагаач иргэд нь гэрийн үйлчлэгч, асрагч, гэрийн цэвэрлэгч, хүүхэд асрагч, засвар үйлчилгээний ажил дээр ойролцоогоор 30 хувийг цагаач иргэд бүрдүүлж байна.

АНУ-ын эмч нарын ойролцоогоор 30 хувь нь цагаач иргэд. [33]

- АНУ нь 1970-иад оноос хойш үйлчилгээ дутмаг газруудад цагаач эмч нарт түшиглэсээр ирсэн.
- АНУ-ын хүн амын насжилтын асуудал, эрүүл мэндийн үйлчилгээний ажиллагсдын тоо багасаж буйтай холбогдуулан цагаач иргэд нь насжилт улам бүр өндөр байгаа тус улсын хүн амыг асрах ажиллах хүчний голлох үүргийг үргэлжлүүлэн хүлээх юм.

Цагаач иргэд улсын нийт эдийн засгийн гаралтыг нэмэгдүүлдэг. [34]

- 2013 оны судалгаагаар гадаад төрсөн ажиллагсдын жилийн улсад оруулж буй мөнгөн хөрөнгө оруулалт нь ойролцоогоор 2 триллион доллар буюу энэ нь жилийн ДНБ-ий 10% орчим болно. [35]

Сайн хуульчилсан нөхцөлд эдийн засгийн тогтвортой байдал нь боловсрол, эрүүл мэндийн салбаруудад үйлчилгээний хүртээмж байж болно. [36]

- Хуулийн байр суурь нь эдийн засгийн хувьд нэг шат ахих боломжийг цагаач эцэг эхчүүдэд олгох чухал арга бөгөөд нь цааш цаашдын үр хойчид эергээр нөлөөлөх юм.

Эцэг эхчүүдэд боломж бололцоо олгон дундаж давхаргаас шилжих хуульчлал нь тэдний боловсролд оруулж буй санхүүгийн хөрөнгө оруулалт юм. [37]

- Боловсрол нь анхны залуу үед илүү сайжруулсан эдийн засгийн тогтвортой байдал руу хөтлөх нэгэн чухал арга зам төдийгүй, боловсрол нь хоёрдогч залуу үеийн хөдөлгөх боломжтой зэвсэг гэлтэй.

Цагаач иргэд нь улсын нийт эдийн засгийн гаралтыг нэмэгдүүлж, цаашлаад хойч үед чухал хөрөнгө оруулалт авчрах юм. [38]

- Дотоодын Нийт бүтээгдэхүүн, эсвэл улсын нийт эдийн засгийн гаралтын хувь хэмжээг цагаач иргэд бүрдүүлдэг.
- Цагаач иргэдийн эдийн засагт үзүүлж буй үр нөлөөний талаарх Шинжлэх ухааны үндэсний академиас гаргасан судалгаагаар, нэг болон гуравдугаар залуу үеийнхэн, цагаач иргэд улсын төсөвт өөрсдийн олдгоос илүү их хэмжээний мөнгөн хөрөнгө оруулалтыг оруулдаг болохыг тогтоожээ. АНУ-д амьдарч буй дундаж нэг болон гуравдугаар залуу үеийн цагаач иргэд улсын төсөвт оруулж буй цэвэр орлого нь \$1,700, ба \$1,300 байна.
- Калифорни хотноо, нийт цагаач иргэдийн цэвэр татвар нь гуравдугаар залуу үеийнхний дунд дундаж орлого \$1,050 байна.

Цагаач иргэд байхгүй болох нь ажиллах хүчний ноцтой хомсдолыг авчирна.

- АНУ-ын Эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт гарч буй ажиллагсдын хомсдолоос гадна цагаачдын АНУ-ын боловсролын салбарт үүсж буй бэрхшээл нь тун ноцтой юм.
- Багш нарын дутагдалтай байдал, нэн ялангуяа, математик, байгалийн ухааны хичээлийн хувьд АНУ-ын Балтимор ба Чикаго зэрэг хөдөө орон нутгаас хотын томоохон мужуудад үүсээд буй асуудал байна. Эдгээр дүүргийн олонх нь тухайн ажлын байрыг нөхөхийн тулд орон нутгийн багш нар хүрэлцэхгүй тул цагаач багш нарын шаардлага тулгараад байна.[39]



# **ХҮҮХДИЙН НҮДЭЭР** **Нэг Үндэстэний Хороонд** **зориулсан Хелен Зиагийн эссе**

Хүүхэд насны минь хамгийн эртний дурсамж гурван настай байх үе буюу 1950-д оны дунд үед байдаг. Би Нью Жерси дэх хотын хамгийн том цэцэрлэгт хүрээлэн болох Рүүзевэлт цэцэрлэгт хүрээлэнд байлаа. Дэрвэгэр кринолин даашинз өмссөн би бариу, загатнасан мэдрэмжээ үл тоон зогсож байв. Бараг таван настай ах минь сайхан хүрмээ ковбой цамцан дээрээ өмсчихсөн, хоёр настай дүү маань бидэнтэй нэгдсэн байлаа.

Хүүхдүүд бид нар цэцэрлэгт хүрээлэнд гайхамшийг цагийг өнгөрүүлж байв. Цагаач эцэг эх маань толгод дээр байх томоо гэгчийн тоосгон байшин руу очих гээд бидний түрхэн зуур орхисон байлаа. Өвстэй довцог даган би гулгаж, байдгаараа инээж байв. Дахин гулгахаар довцог өөдөө гүйн, муухай болсон даашинзан дээрээ өвсний толботой болохыг минь хэн ч хориглохгүй байлаа.

Удалгүй аав минь агуй шиг байшинд аваачихар ирсэн юм. Согтууруулах ундаа, ариутгагч бодис болон бусад хүчтэй үнэр сэрүүн бөгөөд харанхуй хонгилд нэвт шингэсэн байв. Миний Мэри Жэйний гутал хатуу хулдаасан шалан дээр тог тог дуугарна. Биднийг ээж дээр очиход ээж эмнэлгийн шинжилгээгээ өгчихөөд биднийг хүлээн зогсож байв. Том, босоо рентген аппаратыг ойролцоо байрлуулсан байв.

Ээж минь ч бас хамгийн сайхан хувцсаа өмссөн байж билээ. Аав ч тэр. Эмчид очно гэдэг тусгай үйл явдал байж дээ. Ээж минь сүрьеэтэй гэж оноглогдсон байлаа. Хятад дахь дайны олон жилийн өлсгөлөн, хомсдол, Америкт дүрвэсэн, бичиг баримтгүй дүрвэгч байх стресс, гурав хүрэхгүй жилийн дотор гурван хүүхэдтэй болсон гээд ээжийн минь дархлааны тогтолцоо доройтсоноос үүдэн сүрьеэгийн савханцар нянг дийлээгүй байв. Цэцэрлэгт хүрээлэнд байх Рүүзевэлт эмнэлэг өндөр халдвартай өвчний тархалтыг зогсоох зорилготой мужаас явуулдаг сүрьеэгийн сувиллын газар байсан юм.

Хэдийгээр сүрьеэ үхлийн өвчин байхаа больсон ч ээж минь хорионд орох ёстой болсон нь тэр байж. Эцэг эх маань эрүүл мэндийн даатгалгүй, төлбөр төлөх чадваргүй тул засгийн газар сонгосон байлаа. Өнөөдрийн өөрийн давуу талаас харахад эцэг эхийгээ би азтайд тооцдог: эцэг эхийн маань ач холбогдолгүй цагаачлалын статус, ээжийн минь сүрьеэтэй болсон ч гэр бүл минь ээжийн ноцтой өвчнийг эмчлэх боломжтой байжээ. Ээжийн эрүүл мэндийг, учирсан хүн бүрийг нь цаашид эрсдэлд оруулаад байх шаардлага эцэг эхэд минь байхгүй болсон байв.

Эмнэлгийн бусад тусламжийн хувьд, эмчид үзүүлэх мөнгөгүй байсан болхоор аав минь хүүхдүүдээ өвтгөхгүйн тулд бидэнд үглэдэг байлаа. Эмнэлгийн төлбөрийг төлөх гэж яддаг байсан аав минь “Хэрэв та нар машинд мөргүүлвэл, Волксвагенд биш Кадиллакт л мөргүүлээрэй!” гэж их загнадаг байж.

Кадиллак унадаг хүн эмнэлгийн төлбөрийг хийж чадна гэж аав минь ойлгосон байсан биз. Танк шиг Кадиллак биднийг хавтгай болтол дарж орхино доо гэж би аавынхаа тайлбарт чимээгүйхэн эргэлздэг байв. Азаар үүнийг бид хэзээ ч олж мэдээгүй юм.

Нийгмийн халамжийн дүрэм тэр үед мөрдөгддөг байлаа. Гэхдээ МакКарти "дотоодын дайсан" гэгдэн айхтар шалгагдаж байсан тэр үед уг дүрэм нь эрүүл мэндийн суурь тусламж, хоол хүнс эсвэл орон байрны тусламж авах шаардлагатай цагаач гэр бүлд хамаардаггүй байв. Өдгөө Цагаан ордон нь Нийгмийн халамжийг бороохой болгон ашиглаж, хууль ёсны цагаачдад гэр бүлийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдал, үндсэн эрхээ эсвэл цагаачийн статусаа аюулд оруулахын аль нэгийг хүчээр сонгоход хүргэж байна.

Өнөөдөр энд хууль ёсоор оршин сууж байгаа цагаачид өвчтэй хүүхэд, гэр бүлийн гишүүддээ эмнэлгийн үйлчилгээ авахаас ч айж байна. Энэхүү Нийгмийн халамжийн дүрэм нь тэдний эсвэл гэр бүлийн гишүүдийнх нь хууль ёсны цагаач гэсэн статуст аюул учруулах вий, байнгын оршин суугч эсвэл АНУ-ын иргэн болоход нөлөөлөх вий эсвэл албадан гарахад хүргэх вий гэхээс айн хоол хүнс, орон бйрны тусламж авахгүй байна.

Үнэн хэрэгтээ тэдэнд санаа зовох хангалттай шалтгаан бий. Учир нь одоогийн Захиргаа Африк, Ази, Латин Америкийн "мянга мянган үндэстэн" -ээс шилжин ирэгсдийн эсрэг бие махбодийн болон хүнд суртлын хана босгохыг зорьж байна. Нийгмийн халамж болон бусад саадыг бий болгосноор цагаачдад баян чинээлэг, цагаан арьстан биш л бол тус улсад нэвтрэхийг хориглохоос гадна гэр бүл салах үндэслэлтэй болж; хүний үндсэн эрхийг зөрчиж, өвчин, үхэлд хүргэсэн нөхцөлд хүүхдүүд болон насанд хүрэгчдийг шоронд

хорих; аюулгүй буцаж ирэхээс үл хамааран хүмүүсийг, тэр дундаа үхлийн өвчтэй хүүхдүүд болон бусад улсуудаас үрчлүүлж байсан, Америкчууд өргөж авсан насанд хүрэгчдийг албадан гаргаж байна. Түүх, нэг л өдөр ийм элэглэл доромжлолыг хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг гэж тэмдэглэх болно.



1950-д онд эцэг эхийн минь визний хугацаа дууссан бөгөөд Коммунист хувьсгал гарсанаар тэд Хятад буцаж очиж чадаагүй юм. Тэднийг албадан гаргах гэж байсан ч АНУ-ын цагаачийн албаныхан Америкт төрсөн хүүхдүүдийг, МакКартигийн тэдгээр хүнд хэцүү он жилүүдэд хүртэл, эцэг эхээс нь салгах нь хэтэрхий дэндсэн хэрэг болно гэж үзсэн. Цаг хугацаа өнгөрч, эцэг эх минь АНУ-ын иргэн болж, Америкт төрсөн зургаан хүүхдээ өсгөсөн. Тэр зургаан хүүхдийн тав нь төрийн албан хаагч болж Америкийн байгаль орчин, арилжаа, банк, орлого, ижил тэгш орон сууц, ахмад дайчдын асуудалд хүч нэмэн ажиллаж байна. Бидний гурав маань АНУ-ын Тэнгисийн цэрэг, Тэнгисийн явган цэрэг, Агаарын нисэх хүчинд хүндэтгэлтэйгээр үйлчилсэн. Хэрэв гэр бүл минь албадан гаргалтаас болж салцгаан, эсвэл эмчлэгдээгүй өвчнөөс болж зовж шаналсан бол энэ бүх хувь нэмрийг оруулж чадахгүй байсан билээ.



Эцэг эхийнхээ албадан гаргагдах дөхсөн тухай би Шанхайгаас гарсан сүүлчийн завьномоо дуусгаж байхдаа мэдсэн бөгөөд цагаачлалынх нь хурлын протоколын түүхийг оруулахыг зорьлоо. Нийгмийн халамж зэрэг цагаачдын эсрэг дайралт Вашингтоноос гарах болж, бүр зарим улс төрчид хүртэл ашиг тус хүртсэн гэгдэх хууль ёсны цагаачдаас иргэншлийг нь дээрэмдэхийг уриалж байна. Миний номон дахь илчлэлтүүд 87 настай ээжид минь аюул учруулах вий гэж санаа зовж эхэлсэн би тэдгээрийг устгах тухай бодож үзсэн.

Харамсалтай нь номоо дуусгахаас минь өмнө ээж минь өнгөрсөн болхоор ээжийнхээ цагаачийн түүхийг би хасаагүй юм. Хэдий би ээжийгээ хачин их санадаг ч, өнөөдөр цагаачдад юу тохиолдож байгааг үзэж чадахгүйд нь баярладаг. Өөрийнх нь цагаачилсан улс Нийгмийн халамж гэх нэрийн дор шинэ үеийн цагаачдад ямар гээчийн харгислалыг учруулж байгааг үзээд ээж минь айх байсан биз.

Бүх хүүхэд хаана төрсөн, ямар өнгөтэй арьстай, ямар шашин шүтдэг, ямар хэлийг хамгийн сайн мэддэг, нас, хүйс, орлого, боловсрол, хөгжлийн бэрхшээл болон биднийг хүн болгодог бусад шинж чанараас болж гэр бүлээсээ салах, цагдан хоригдох, тодорхойгүй байдал орж, насан туршдаа сэтгэлийн эмгэгтэй болж шаналах бус харин аз жаргалтай дурсамж бүтээх боломж байх ёстой.

Америкийн гуравны нэгээс илүү нь цагаачидтай холбоотой эсвэл цагаачид өөрсдөө байдаг. Өмнөө байх аюултай зам мөрийг туулах, нөхөрсөг бус газар нутагт нүүлгэн шилжүүлэх бэрхшээлийг даван туулах тууштай хүсэл, өөрсдийнх нь нэлээдгүй өөр соёлд зохицох шаардлагыг зоригтойгоор туулсан тухай түүх хүн бүрт л байдаг. Тэд тэсвэр тэвчээрээрээ урам зориг өгч, гаргасан золиослол нь нь хойч үеийнхэнд үр өгөөж өгөхгүй байсан ч гэсэн амар амгалан, хоргодох дээвэр олж авахын тулд бүхнийг эрсдэлд оруулахад хүн бэлэн байдаг болохыг харуулдаг.

Миний эцэг эхийн түүх өнөөдрийн дүрвэгчдийн хямралыг хүүхдийн нүдээр харах боломжийг надад өгсөн. Хүмүүс яагаад гэр бүлийнхээ аюулгүй байдлын төлөө бүгдийг эрсдэлд оруулж, хил дээр нулимс асгаруулагч хийтэй нүүр тулж, резинэн завиар яндашгүй далайг зүрхлэн туулж, дараагийн завь, онгоц, вагон эсвэл автобус нь сүүлчийнх нь байх вий гэж айж байгааг бусдад ойлгуулахын тулд дүрвэгчдийн илүү олон үеийг өнгөрүүлэх ёсгүй юм.

Үгүй бол энэ үндэстэн цагаачид болон дүрвэгчид Америкийг хүчирхэг болгодгийг ойлгохын тулд авч чадахаас нь дэндүү ихийг өгсөөр л байх болно.



# Цагаачлалын бодлогын тухай тулаан Хуульд гарсан өөрчлөлттэй ТЭМЦЭХ НЬ

Хятадын болон бусад Ази гаралтай цагаач иргэдийг арьс өнгөний үзлээр гаргасан хориг арга хэмжээ түүнчлэн, ядуу буурай гэдгээр нь цагаач иргэдийг гадуурхаж байгаа нь АНУ-ын түүхийн нэгээхэн хэсэг болсон, Конгрессоос гаргасан цагаачлалын тухай хууль түүний гүйцэтгэх эрх мэдлийг үгүйсгэж буй хязгаарлалт юм.

Орчин цагт буюу 1964 оны Иргэний Хуулийн дагуу, Цагаачлалын хуулийг 1965 онд баталсан байдаг ба хэдэн арван жилийн хугацаанд мөрдөж ирсэн үндэсний квотын системийг устгаж, Хойд Европын цагаачдын хувьд цагаачлалын эрхийг үлдээж байгаа хэрэг юм. Анхандаа, Латин Америк, Ази, Африкийн цагаачид иргэд ижил тэгш эрхтэй амьдарч байсан ба-ингэснээр ч Ази, Мексик гаралтай цагаачид нэмэгдэх болсон.

Тэр цагаас хойш, өдгөө хүртэл, цагаачлалын эсрэг хууль тогтоомж нь шинжээр цагаач иргэд авахыг хориглон, түүнээс гадна төрийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Эдгээр засаг захиргааны өмгөөллийн байгууллага, Конгрессын хуулийн төслүүд, холбооны шүүх дэх хууль эрх зүйн асуудал эрхэлсэн байгууллагуудыг олон нийт хүчтэй эсэргүүцсээр ирсэн байна. Хамгийн томоохон арга хэмжээнүүдэд

## **1970иад оноос хойш- 1980иад он хүртэл**

Холбооны хууль тогтоомжийн дагуу цагаач иргэдийн гэр бүлд ах, эгчдээ визний мэдүүлэг хүсэх эрхийг бууруулах хязгаарлалт тогтоосноор, Ази гаралтай америкчуудад хууль батлан гаргагчдыг ятган сэхээрүүлэх компанит ажлыг амжилттайгаар явуулсан төдийгүй томоохон цагаач иргэд, дүрвэгчдээс бүрдсэн Ази Ирланд гаралтай цагаач иргэдийн нийгэмд гэр бүлээрээ нэгдэн нийлсэн билээ.

## **1994**

Калифорнид сонгогчдын 187-р саналаар батлагдсан хориг арга хэмжээ болох гэнэтийн бус эрүүл мэндийн халамжийн үйлчилгээ, улсын боловсрол болон бусад үйлчилгээг авах эрхийг бичиг баримтгүй цагаач иргэдэд хориглосон бөгөөд энэхүү арга хэмжээ гарснаас нэг өдрийн дараа тухайн шийдвэрийг эсэргүүцсэн захидал нэхэмжлэл шүүхэд хүргэгдэж, холбооны шүүхээс үүнийг үндэслэлгүй гэж үзжээ. Ингэснээр хэзээ ч 187-р тогтоол хориг хэрэгжиж байгаагүй юм.

## **1996**

187-р хориг тогтоолын цагаач иргэдийг эсэргүүцэх асуудлын дагуу Конгрессоос Хувийн Хариуцлагатай байдал, Ажлын байрны Боллоцоо Эвлэрлийн тухай Хууль тогтоомжийг баталсан нь/ хожим нь халамжийн шинэчлэл гэж үздэг/ бөгөөд улсын халамж авах эрхээс цагаач иргэдийг хязгаарлаж,

шинэ хуулийн дагуу байнгын оршин суугчдыг холбооны олон нийтийн халамж үйлчилгээнд хамрагдах эрхийг 5 болон түүнээс дээш жил тус улсад амьдарсан тохиолдолд олгохоор шийдэж, шинээр цагаач иргэдэд хязгаарлалтын бодлого гаргаж байсан.

Холбооны улсын халамж авах боломжгүй болсон тул, цагаагч иргэд нэгдэн нийлж улсын санхүүжүүлэлтээр бүрддэг хөтөлбөрүүдийг хөгжүүлэх сайжруулах тал дээр мужийн хэмжээний ажлыг зохион байгуулжээ. Ингэснээр Калифорни мужийн Сакраменто хотод олон зуун цагаач төлөөлөгчид өөрсдийн асуудлыг шийдвэрлэхээр цугларсан бөгөөд энэ нь өдгөө жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг анхны "Цагаачдын өдөр" болон тэмдэглэдэг байна.

## 1999

Цагаач иргэдийн шинэчлэлтийн бодлого хуулийг хэрэгжилтийг зогсоохоор цагаач иргэдийн эрхийг хамгаалах байгууллагууд Цагаачлалын албан, Иргэн Харьяатын үйлчилгээ хариуцан албанаас хүсэлт гаргуулан, энэхүү төрийн халамжийн үйлчилгээний хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь ямар эерэг нөлөөтэй болох талаар тодруулга хүсээд байна.

Иргэн харьяатын албанаас бичгээр тодорхой гаргасан тухайн хүсэлтдээ-Улсын халамжийн үйлчилгээний тухай хуульд хязгаарлалт тогтоож буйг тодруулаад хуулийн дагуу байнгын оршин суугчдад тэр дундаа улсаас олгодог халамжийн мөнгө, байнгын халамж, нийгмийн халамжийн тэтгэмж зэргээр санхүүжиж гол орлогоо болгож буй иргэдийг онцолсон байна.

## 2017

Ерөнхийлөгч Доналд Трамп нь Хүчирхэг хөдөлмөр эрхлэлтийг бий болгох (RAISE) тухай хуулийн төсөл (S.1720) дагуу Америкийн Цагаач иргэдийг шинэчлэх тухай хууль гаргасан нь хууль ёсоор амьдарч байгаа цагаач иргэдийг 50 хувь хүртэл бууруулж, тэдгээр цагаач иргэдийн гэр бүл хамаатан садан, АНУ-ын иргэний эцэг эхийг тус улсад орохыг хориглож буй бөгөөд үүний хамгийн том золиос нь Мексик болоод Ази гаралтай цагаач гэр бүлүүд өртөөд байгаа юм. Хэдэн арван Ази гаралтай Америк бүлгүүд энэхүү цагаач иргэдэд тавьсан хориг, тэдний гэр бүлийн нэгдэн нийлэх хүслээ илэрхийлэн тэмцлийн жагсаал өрнүүлж байв.

Энэхүү S.1720 хуулийн төслийн эсрэгээр, Конгрессын эмэгтэй гишүүн Жюди Чү (H.R.3799) тоот гэр бүлтэйгээ нэгдэн нийлэх тухай хуулийн төслийг санал оруулсан нь цагаач иргэдийг эргэн гэр бүлтэйгээ нэгдэн нийлэх тухай бодлого юм. Эдгээр нь 2019 оны 09-р сарын 01-ний өдрийн байдлаар H.R. 3799 нь 49 хамтран дэмжигчидтэй болж, харин S.1720 – нь 3 дэмжлэг аваад байна.

## 2018

Трамгийн засаг захиргаанаас энэхүү Улсын халамжийн бодлогыг сайжруулан санал оруулсан ба энэ нь дараа шалтгааны улмаас хуулийн дагуу байнгын оршин суугч хууль ёсны цагаач иргэдээс өргөн хүрээний эсэргүүцэлтэй тулгарч мэдэх юм: үүнд хэт залуу, эсвэл хэт хөгшин, боловсролын түвшин, Англи хэлний мэдлэг эсвэл тэд Эрүүл мэндийн болоод, хоол хүнс, орон байрны халамж, тэтгэмж авдаг эсэхээс хамаарна.

Улсын хэмжээнд тухайн хуулийн төсөл, төрийн халамжийн үйлчилгээг шинэлэх бодлогын хүрээнд цагаач иргэд боловсролын компанид ажил зохион байгуулж, олон нийтийн асар их хэмжээний дэмжлэг, санал хураалтыг аваад байгаа юм: үүнд 266,000 санал хүсэл, бараг бүгд тухайн санал оруулсан халамжийн тухай хуулийн төслийн эсрэг санал, үүнээс 23,000 санал нь Ази, Ирланд гаралтай Америк цагаач иргэдээс ирсэн санал байна.

## 2019

Конгрессын гишүүн Чүгийн төлөөлөгч H.R.3222 хуулийн төсөл буюу улсын халамжийн тухай бодлогод санхүүжилт байхгүй болохыг танилцуулж, төрийн халамж үйлчилгээний тухай хуулийг өөрчлөн хэрэгжүүлэх холбооны зардалд хориг тавих тухай аналгыг танилцуулсан нь 2019 оны 09-р сарын 06-ны өдрийн байдлаар Конгрессоос 93 санал дэмжлэг аваад байна.

Цаашлаад цагаач иргэд дээр хандуулсан хориг, заналхийлэл үргэлжилсэн хэвээр байх бөгөөд Трампийн Засгийн газар өрийн халамжийн үйлчилгээний тухай хуулиа сайжруулан баталж хууль ёсны дагуу байнгын оршин суугч иргэд болох хууль ёсны цагаач иргэдийг албадан гаргахаар бэлтгэж байна.


Ингэснээр Нэг Үндэстэн Нийгэмлэг нь Ази, Ирланд гаралтай Америк цагаачдын санал зовнилыг шийдвэрлэх, тэдний дуу хоолойгоо өргөж, АНУ-д үүсээд буй асуудлыг зогсоохоор бусад олон арьс өнгөөр ялгаатай/угсаа гарвал өөр бүлгүүдтэй хамтран тэмцэхээр нэгдэн нийлсэн юм.

## **2019 оны Наймдугаар сар**

Сайжруулсан санал оруулсан улсын тэтгэмжийн шинэчилсэн бодлого нь эцэслэн батлагдаж, 2019 оны 10-р сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр болох юм. Энэ тухай зургаан хуулийн нэхэмжлэх 20 муж, бүс нутаг, засаг захиргааны байгууллагаас хүргүүлээд байгаа бөгөөд тус хуулийн төсөл улсын халамжийн тухай хуулийг өөрчлөн батлах нь хууль ёсны үндэслэлгүй цагаан арьст биш Ази, Латин болон бусад цагаач иргэдийг арьс өнгөөр ялгаварлан гадуурхаж буй хэрэг хэмээн үзэж байна.

**Энэхүү цаг тооны нарийн дарааллын дагуу Игнатий  
Бау судалж, боловсруулжээ.**





# Улсын халамжийн үйлчилгээ нь нийгэм, эрүүл мэндийн салбарын ирж буй заналхийлэл

1800-гаад оны сүүл үед, Массачусетс болон Нью Йорк-д ирсэн Европын цагаачид иргэд нь тус улсын нийгмийн халамжийн бодлого байсан, хууль батлагчид улсын халамжийн үйлчилгээг АНУ-с гадагш ашиглахгүй гэсэн үндэслэлтэйгээр хууль боловсруулж байв. Энэхүү Зүүн Эргийн цагаач иргэдийн эсрэг тэмцэл нь Ирланд болон Италичуудад чиглэсэн бодлого байсан бөгөөд Ирландын цагаачдын толгойлсон Баруун эргийн цагаан арьст ажилчдын бүлэг хятад цагаачдыг эсэргүүцэн үймээн дэгдээж, 1882 онд Хятад иргэдийг улсаас гаргах тухай хууль батлан хэрэгжүүлснээр энэ нь улмаар бүх Азийн цагаач иргэдэд чиглүүлжээ. АНУ-ын нутаг дэвсгэрт нэвтрэн чадсан Ирланд, Итали, Хятад цагаачид нийгмийн амьдралын хүнд хэцүү нөхцөлд амьдарч улмаар улсын эрүүл мэндийн хувьд томоохон аюул нүүрлэсэн юм.

Өнөөдөр, 1999 онд Конгрессын баталсан хязгаарын тухай хуулийг үл тоомсорлож, Улсын Нийгмийн Халамжийн тухай бодлогын санал нь хязгаарын хоригоос даваад байна. Хэрвээ эдгээр цагаач иргэд эрүүл мэндийн халамж, хоол хүнсний халамж, байр орон сууцны туслалцаа зэрэг улсаас эдлэх ёстой халамжийг авах хууль ёсны дагуу оршин суух боломжийг үгүйсгэснээр цагаач иргэд хамгийн сүүлийн үеийн цагаачлалын эсрэг бодлогын шинэчлэл, өөрчлөлтийн талаар цаг тухайд нь, зохих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүйгээр томоохон хэмжээний хохирол, зовлон зүдүүр, өртөг зардалтай цагаач иргэдэд бий болох нь дамжиггүй болно.

Олон ч эрүүл мэндийн байгууллагаас үүнд Америкийн анагаах ухааны нийгэмлэг, Америкийн хүүхдийн эрүүл мэндийн академи зэрэг эрүүл мэндийн тогтолцооны олон чиглэлээр ажилладаг олон эрүүл мэндийн байгууллагууд энэхүү хуулийн төсвийн эсрэг дуу хоолойгоо өргөж байна. Нэг Үндэстэн Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд (AAPIs) комиссын гурван гишүүн нь эмч нар бөгөөд эдгээр эрүүл мэндийн тулгамдсан асуудлын талаарх санал бодлыг нь санал болгож байна.



Тунг Нгуен, эмч.,  
ийн хөгжлийн үйл ажиллагаа хариуцсан дарга  
ААРИ/Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэд



Эмчийн зүгээс хэлж байгаагаа, Эрүүл мэнд бол өвчтөнүүдийн хамгийн том номер нэг асуудал гэдгийг би мэднэ. Тэдний энэ тэргүүний зүйл бол гэр бүлээ асрахын тулд орон гэр олох, хоол хүнс авах юм. Эрүүл мэнддээ зарцуулах хязгаарлагдмал мөнгө санхүү, хоол хүнс, орон байрны баталгаа байхгүй байна гэдэг бол хоёрдох асуудал. Хүмүүс, ард иргэд эрдэс тэжээлгүй хоол хүнс идсэнээр эрүүл мэндээрээ хохирч үлддэг. Цагаач иргэдийн хувьд хаана амьдарч, юу идэх үү гэдгээс гадна тэдэнд нэмэлт дарамт, сэтгэлийн зовиуртай байдаг бөгөөд албадан гаргах эсэх нь эргэлзээтэй, ялангуяа цагаачдад байнга хандсан мэт санагдаж, цагаачлалын бодлогод гарсан өөрчлөлтүүд зэрэг нь ямагт тэдэнд давхар айдсыг дагуулна.

Сэтгэлийн зовиур нэмэгдэх тусам, хүний биед өвчинд тусах химийн урвал нэмэгдэж, ерөнхий биеийн байдлыг улам бүр дордуулж байдаг. Маш олон хүмүүс яаралтай тусламжийн өрөөнд орсноор эсвэл орон гэргүй болсноор бүхнээ алдахад хүрдэг.

Судалгааны дагуу, олон төрлийн угсаа гаралтай байна гэдэг нь асуултыг шийдвэрлэх гарц байж болох, та мэдэхгүй зүйлээ мэдэхгүйтэй адил, ямар нэгэн зүйлийг алдаж өнгөрүүлсэн бол энэ асуудлыг шийдвэрлэхэд таны өөр үзэл бодол хэрэгтэй болж мэднэ. Та олон төрлийн угсаа гарал бүхий багт нэгдсэнээр, үр дүнг илүүтэй харах болно гэжээ.

Энэ бол жинхэнэ ардчиллын төлөөх тэмцэл, ард түмний бүх нийтийн оролцоо байсан цагт бид эдгээр асуудлыг шийдвэрлэх олон олон гарцыг харах болно. Нийгмийн халамжийн үйлчилгээг багтаагаад энэ засгийн газар ард түмнийг бүхэлд нь ялгаварлан гадуурхаж, ирээдүйд үүсэх асуудлыг шийдвэрлэх эерэг гарц шийдлээс биднийг зайлуулж буй хэрэг.



Паул Сонг, MD

үйл ажиллагаа хариуцсан захирал COO/CMO,  
NKMaxAmerica, Inc\*



29 сая Америкчууд ойролцоогоор даатгалд хамрагдаагүй үүнээс олон тооны бичиг баримтгүй, өнгөт арьс бүлгүүд багтах бөгөөд ард түмэн хэдэн арван саяараа жил бүр даатгалгүйн улмаас нас барж, хэдэн зуун сая иргэд эрүүл мэндийн улмаас жил бүр дампуурлаа зарж, 30+ сая даатгалтай Америк иргэд санхүүгийн орлогоос илүү татвар татаас төлдгөөсөө болж болсныхоо төлөө орлогогүй болж байна.

Ард түмний 44 хувь нь даатгалд хамрагдсанаас улсын татвар төлж чадахгүй хүрэх учраас эмчилгээ үйлчилгээгээ хойшлуулахад хүрж, ингэснээр 10 Америк тутмын нэг нь эм, тариагаа зааврын дагуу хэрэглэж чадахгүй, төлбөрийн чадваргүй байгаа бөгөөд энэ мэт мэдэгдээгүй хэдэн сая хүмүүс жилийн татвараа төлж чадахгүй ч амьдралаа залгуулах гэж тэмцэж байна. Энэ бодит гашуун үнэн бид зогсоох, ёс суртахуунгүй эрүүл мэндийн халамжийг үйлчилгээг өөрчлөх цаг ирээд байна.

Санал оруулсан шинэ улсын халамжийн төсөл нь ард түмний эрүүл мэндийн байдлыг улам бүр дордуулахаас цаашгүй. Цагаач иргэд, тэр дундаа Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийг багтаагаад олон цагаач иргэдээс бүрдэх энэ улсын хувьд тэдгээр иргэд нь даатгалд хамрагдаагүй, даатгалд хамрагдах боломжгүй байсаар байна. Америкт амьдарч байгаа Ази, Номхон далайн орнуудаас цагаачлан ирсэн иргэдийн бүлэг, Солонгос гаралтай Америкчууд ихэнхдээ даатгалгүй, гэтэл хачирхалтай нь Солонгос улс эрүүл мэндийн халамжийн үйлчилгээгээрээ дэлхийд хамгийн хөгжингүй орны нэгд зүй ёсоор тооцогддог байх юм.

Нэгэн хорд хавдар судлаачийн үзэж буйгаар, Би эрүүл мэндийн халамжийн мөнгөөр эмчлүүлж буй өвчтөнүүдийг эмчилдэг—тэднээс олон тооны хүмүүс нь хууль ёсны дагуу амьдардаг цагаач иргэд байдаг. Эрүүл мэндийн халамж нь хууль ёсны цагаач иргэдийн хувьд эрүүл мэндийн үйлчилгээгээ авснаар эргээд ногоон карт эзэмших боломжгүй болох вий гэсэн айдас, тэр бүү хэл тэдний үр хүүхдүүд нь өвчин тусахад, эсвэл эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ хийлгэхэд хүндлэл үүсэх байх гэсэн айдсыг дагуулж байна. Жишээ нь, нэгэн цагаач эмэгтэй хөхөн дөх хавдар ургацгаа тоохгүй орхих нь эргээд эрт үедээ эмчилгээ хийлгээгүй эсэхээс хамаарч үхэл амьдралын маш том ялгаа гарч мэднэ.

Миний хувьд энэ өөрчлөлтөөс аль хэдийнээ зүрхшээж айгаад эхлэлээ бид цаашдаа хэрвээ өвдсөн тохиолдолд илүү том хавдар, үсэрхийлэл нь би болсноор эдгээр хүмүүс, бидний нэгэн адил-бидний хөрш, газар тариалан эрхэлж буй ард иргэд, гэр цэвэрлэгчид, хүүхэд хөгшид асрагчид бид нь энэ айдас дунд байна. Эрүүл мэнд гэдэг асуудал бол манай нийгмийн хамгийн эрүүл мэндээр толь мэт харагдаж буй тусгал гэж хэлж болно гэжээ.



Кю Рэе, MPP., MD.

VP/Эрүүл мэндийн үйлчилгээ хариуцсан ахлах ажилтан  
IBM\*



Би анхан шатны эмчийн мэргэжилтэй, над дээр гэр бүлдээ илүү их боломжийг эрэлхийлэн Америкт ирсэн энэ нийгмийн бүрэлдүүлэгч нэгэн эд эс болж буй Латин Америк, Зүүн Өмнөд Ази, Зүүн Европын өнцөг булан бүрээс ирсэн олон цагаач иргэд ирж эмчлүүлдэг. Тэдгээр цагаач иргэдийн Америкт ирсэн нэгэн үнэ цэнэ нь энэ улсын цагаач иргэн болсноор тодорхой амьдралын баталгаажиж, цагаач иргэд өөрсдийн шинэлэг, өөрчлөлт, олон талт байдлыг бий болгож буй юм.

Би энэ улс орон даяар эрүүл мэндийн ялгаатай байдлыг хөдөө орон нутаг, хотын эрүүл мэндийн төвүүдэд харж байна. Цагаачдын эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгчид төлбөр төлөх чадвараас үл хамааран эдгээр олон янзын хүн амд үйлчилдэг орон даяар, хөдөө, хотын эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ явуулж байна. Эдгээр цагаачдын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид нь хүүхдүүдээс асанд хүрэгчид хүртэл өвчтөнүүдийн гэр бүлийн гишүүдийн хамт эмчилгээ үйлчилгээ үзүүлсээр байна. Тэд Америкийн нийгмийн хөдөлгөгч хүч гэж хэлж болно.

Энэ улс цагаач иргэдийн асар их иргэдээс бүрддэг. Иймд тэд мөн адил эрүүл мэнд, боловсрол, ажлын байрны тэгш нөөц шаардлагатай, энэ улсад өөрийн хувь нэмрээ оруулж буй ард түмэн, тэдний гэр бүл, нийгмийн бүлэг эргээд улсаас олгох боломжид хамрагдах нь зүйн хэрэг.



“Манай эцэг бүх насаараа Цагаачлал, Иргэн харьяатын албанд админаар ажилласан би цагаач иргэд энэ улсыг хэрхэн хүчирхэгжүүлэн хөгжүүлж ирсэн болохыг харж өссөнийхөө хувиар—хүн нэг бүр эрхтэйн адил бид тэдэнд өртэй гэж боддог. Иймээс Нэг Үндэстэн нийгэмлэг нь эдгээр цагаач иргэдэд тавьсан бүх аймшигт хоригийн эсрэг хүчтэй тэмцэн ажиллаж байгаа юм.”

Скотт Коффин

Эрүүл мэндийн Аламеда төвийн Гүйцэтгэх захирал,





# Цагаачид эдийн засгийг улам хүчтэй болгодог ЦАГААЧ ИРГЭД БОЛ ЭНЭХҮҮ АСУУДЛЫН ШИЙДЛИЙН НЭГЭН ХЭСЭГ

Америкийн Нэгдсэн улс байгуулагдахаас хойш, Бэн Фланклин дотоодод бий болгосон асуудалд цагаач иргэдийг буруутган цагаачдын эсрэг Пенсильванийн колонид өвчлөл бий болсонд Германчуудыг буруутган ингэснээр цагаачлалыг эсэргүүцэгчид цагаачдыг дотоодын асуудлаар байнга буруутгасаар байлаа. Олон улсаас тэр дундаа Африк, Ази, Латин Америк зэрэг "өнгөт нийгмийн хүрээ" –нээс ирсэн цагаачлагчид үнэндээ улсын эдийн засгийг уналтад хүргэж, Америк ажилчдаас ажлын байр булааж авсан хэмээн буруутгагдаж ирсэн. Гэтэл сүүлийн жилүүдэд энэхүү цагаач иргэдийг эсэргүүцэх хязгаарлалтыг дахин тогтоохоор, тэднийг гэр бүлээс нь салгаж, хүнлэг энэрэнгүй бус нөхцөл байдлыг бий болгож, хэд хэдэн хүний аминд хүргэж; албадан гаргах; орогнол хүссэн хүмүүсийг хүний эрхийн зөрчлөөс буруутган; АНУ-д иргэншил хүч ирсэн Тэдгээр Мөрөөдөгчдийн иргэншил хүсэх замыг нь үгүйсгэн няцааж; нийгмийн халамжийн тухай хууль дүрмийг хүртэл өөрчлөн баталж удаа дараа шахалт үзүүлээд байна.

Гэхдээ олон ч судалгаагаар, Эдийн засгийн Бодлогын хүрээлэнгээс үзэж буйгаар энэхүү дээр дурдсан хоригийг хүчингүй болгож, чухалчлах асуудалдаа анхаар цаг ирээд байна:

- АНУ-ын ажилчдад ирж буй энэхүү сорилт нь үнэндээ хөдөлмөрийн зах зээл дээрх цагаагч энгийн иргэдийн асуудал биш, нийт улс үндэсний цагаачлалын тогтолцоо ажилчин ангид үйлчлэхгүй байгааг харуулж байна. Эсрэгээрээ, энэ нь хууль ёсны баталгаажуулалт байхгүй, баталгаажсан ч түр хугацаанд ажиллах эрхтэй цагаагч иргэдийн хөдөлмөрийг мөлжиж, ашиг хонжоо хайсан ёс зүйгүй ажил олгогчдын бай болж, хуулийн хүрээний асуудал болох цалин тэтгэвэр тэтгэмж буурах, дарамт шахалт бий болох хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, ажил олгогч нартай хариуцлага тооцох асуудал дээр цагаагч иргэдийн хүчин мөхсөдөж байна. Энэ нь цагаагч гэлтгүй Америк ажилчдад, иргэдэд, байнгын хуулийн дагуу оршин суугч мөрөөрөө ажиллаж буй хүмүүст хүнд цохилт болоод байна.
- Бодлого, хуулийн хүрээнд хуулийн дагуу байнгын оршин суугчдаас аваад одоогоор хараахан баталгаажуулалт аваагүй цагаагч хүн ам хүртэл АНУ-ын цагаачлалын тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөж, түр хугацааны ажлын визийн хөтөлбөрт тавигдах хууль дүрмийг шинэчлэн батлах, цагаагч ажилчдын үүнд хандсан хариу арга хэмжээ авахаас сэргийлэн хөдөлмөрийн стандартын хэрэгжүүлэлтийн санхүүжилтийг улам бүр нэмэгдүүлж, түр хугацааны ажлын визтэй хүмүүсийг ажилд авахыг ажил олгогчдоос бүрмөсөн таслан зогсоох хориг тавьж буй нь тэд цагаачлалын болон хөдөлмөрийн тухай хуулийг зөрчиж буй хэрэг юм. [1]

## **Бодит мэдээлэл, цагаач ажилчид нь энэ улсын нийгэмд оруулж буй ашиг тусыг харуулах болно. Тэд Америк ажилчдыг багтаагаад бүх**

- Нийт эдийн засаг, бүх АНУ-ын ажилчдад уг саяхан батлагдсан цагаачлалын тогтолцоо, хуулийн хүрээний асуудал нь хүнд цохилт болж, цалин хөлсөнд өөрчлөлт орох, хууль ёсны баталгаажуулалт байхгүй, баталгаажсан ч түр хугацаанд ажиллах эрхтэй цагаач иргэдийн хөдөлмөрийг мөлжиж, ажил олгогчдод ашиг хонжоо хайх болоод байна. [42]
- Цагаач иргэд нь АНУ-ын Хөдөлмөрийн дэд бүтцийн үндэс хэсэг мөн, голдуу Америкчуудын хийхийг хүсэхгүй /Цагаач гаднын иргэдийн 32.5% байхад Америк уугуул иргэдийн 15.9% хувь байна/ үйлчилгээний ажлын байранд ажиллаж, эрүүл мэндийн асаргаа, сувилгаа асрамжийн үйлчилгээ хийж, асран хамгаалах үйлчилгээ, хоол хүнсний бэлтгэл, үйлчилгээний ажил, барилга, газар шорооны ажил, цэвэрлэгээ, хувийн асаргаа зэрэг ажлуудыг хийдэг билээ. Гадаадад төрсөн ажиллагсдын түгээмэл хийдэг ажил нь үйлчлэгч, тогооч, жолооч, зөвшөөрөл бүхий сувилагч, касс, хөдөө аж ахуйн ажилтан багтана.[43]
- Цагаач иргэд АНУ-д төрсөн ажиллагсадтай харьцуулахад 15%-р илүү цагаар ажилладаг ба ажлын өдөр, амралтын өдөр ялгалгүй 8:00 pm -с 6:00 am хүртэл ажилладаг. [44]

- Шинэ ирж байгаа цагаачдын 83% нь ерөнхий боловсролын сургууль төгссөн хөдөлмөрийн насны хүмүүс байдаг. Харин АНУ-д 1990 онд энэ үзүүлэлт 53% байсан бол өнөөдрийн байдлаар АНУ-д төрсөн иргэдийн ерөнхий боловсролын түвшин 79% - тай байна. [45]
- Цагаач иргэдийн хүүхдүүд-хоёрдогч хойч үе- хүн амын хамгийн хүчирхэг эдийн засгийн болоод төсвийн хөрөнгө оруулагчид гэж үздэг. Урт хугацааны төсвийн тооцооллоор үзвэл, цагаач иргэд болоод тэдний хойч үед нь маш эерэг үр дүнг авчрах төдийгүй хөдөлмөрийн хүчирхэг зах зээлийг бий болгох, шинэчлэлт, өсрөнгүй хөгжил, гарааны бизнесийн үйл ажиллагаа зэрэгт томоохон байр суурь эзэлдэг.[46]
- Цагаач биш АНУ-ын хөдөлмөрийн ажиллах хүч нь багасаар байгаа бөгөөд холбооны засгийн газар Нийгмийн аюулгүй байдлын хөтөлбөрөөс цаашдаа багасаар байх бөгөөд дан ганц Америк ажиллагсдаас ирэх орлого нь настай хүн амыг тэтгэх, эдийг засгийн өсөлтийг дэмжих зэрэгт хангалтай биш гэж Пэв Судалгааны төвөөс үзэж байна.[47]
- Нийгмийн халамжийн үйлчилгээ яг төлөвлөсөн дагуу явуулбал 17,700 хүртэл ажлын байр Калифорни мужаас л гэхэд устгаж болзошгүй, түүнчлэн энэ нь эргээд орлогын татвар, худалдааны татварын орлого буурахад хүргэнэ.[48]